*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны*
*98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт*

**ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН АВТО ЗАМЫН ХЯНАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ ШАГДАРХҮҮГИЙН СҮНЖИДМААГИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/Д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. "Авто замын салбарын хууль тогтоомж, бодлого шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах, холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн хяналт шалгалтын ажлыг орон нутагт зохион байгуулах, хуулийн хэрэгжилтийг хангуулах" зорилтын хүрээнд** | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ 1.1.<br>Авто замын хяналтын чиглэлээр хийх төлөвлөгөөний санал боловсруулан холбогдох газарт хүргүүлж, батлагдсан төлөвлөгөөг орон нутагт хэрэгжүүлэх, тайлагнах бүртгэх; | Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний тоо<br><br>Хэрэгжилт /хувь/<br><br>Тайлагналт /хувь/ | 12<br><br>100 %<br><br>100 % | 5<br><br>100%<br><br>100% | ЗТЯамнаас ирүүлсэн 11/327 албан бичгийн дагуу 2025 онд Орхон аймаг, Баян-Өндөр, Жаргалант сумуудын хэмжээнд барилга угсралт, их засвар, шинэчлэлт хийгдэх 58 авто зам, замын байгууламжийн ажлын судалгааг гаргаж хүргүүлсэн<br><br>Зам, тээврийн сайдын 2025 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн А/10 дугаар тушаалаар батлагдсан Зам, тээврийн салбарт 2025 онд төлөвлөгөөт хяналт шалгалт хийх обьектын жагсаалтанд 12 обьектыг батлуулснаас тайлант хугацаанд 5 обьектод төлөвлөгөөт шалгалтыг хийж хэрэгжилтийн хувь 100.<br><br>Төлөвлөгөөт хяналт шалгалтыг http://shilenkhyanalt.gov.mn/ шилэн хяналтын системд баталгаажуулж, тайланг 100 хувь илгээсэн. | I/02-VI/06 | 100 |
| 2 | Арга хэмжээ 1.2.<br>Хяналт шалгалтын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, цаашид авах арга хэмжээг төлөвлөх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох болон | Хяналт шалгалтын үр дүн дээшилж, эрх зүйн | - | 1 | Эрсдэлийн шалгуур үзүүлэлтэд:<br>-Авто зам, замын байгууламжуудын хүчин чадлыг тооцох.<br>-Ашиглалтын хугацааг тооцож байх саналуудыг өгсөн.<br>"Хяналт шалгалт хийх нийтлэг журам"-д | I/10-31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тулгамдсаж буй асуудлыг шийдвэрлүүлэх талаар санал боловсруулах; | орчин сайжирсан байна. | | | 1.Улсын байцаагч нь хянан шалгах үүргээ гүйцэтгэхэд шаардагдах хөдөлмөр хамгааллын хувцас болон техник хэрэгслээр хангагдах.<br>2. Хүний амь нас, эрүүл мэнд, нийтийн болон орчны аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдэл, хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох зорилгоор нийтийг хамарсан үйл явдал, нийтээр тэмдэглэх, баяр болон тэмдэглэлт үйл явдал, улирлын чанартай ажил, үйлчилгээ эхлэхээс өмнө урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж болно.<br>3.Гүйцэтгэлийн шалгалтыг улсын байцаагчийн албан шаардлагаар өгсөн үүрэг даалгаврын хүрээнд хийх тухай 3 саналыг оруулж, журамд тусгуулсан. | | |
| 3 | Арга хэмжээ 1.3.<br>Авто замын хяналтын чиглэлээр хяналт шалгалтын обьектын эрсдэлийн үнэлгээ хийх, хяналт шалгалтын мэдээллийг цахим системд бүртгэх; | Обьектын тоо<br><br>Цахим системд бүрэн бүртгэсэн байна | 103 | 88 | -88 обьектод эрсдэлийн үнэлгээ хийж, Шилэн хяналтын цахим системд бүртгэсэн.<br>-Обьектын эрсдэлийн үнэлгээг хийж, Их эрсдэлтэй үнэлэгдсэн 11, дунд эрсдэлтэй 1 обьектод төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийхээр төлөвлөж, Зам, тээврийн салбарын 2025 оны хяналт шалгалтад хамрагдуулж, ЗТСайдын 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/10 тушаалаар батлуулсан. | | 100 |
| 4 | Арга хэмжээ 1.4.<br>Авто замын хяналтын чиглэлээр аж ахуйн нэгж байгууллагын дотоод хяналтыг сайжруулах, нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх, иргэдийн хэрэглээ, үйлчилгээний соёл, мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг мэдээлэл, зөвлөмжөөр хангах; | Хуулийн хэрэгжилт хангагдсан байна. | 21 Зөвлөмж | Дотоод хяналтын чиглэлээр 1 удаагийн сургалт зохион байгууна. | 1.Авто замын захиалагч, гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүд, “ХББЗА” ОНӨААТҮГ-ын инженер, холбогдох мэргэжилтнүүдэд ”Авто замын салбарын хяналт шалгалтаар илэрч буй нийтлэг зөрчлүүд” сэдэвт сургалтыг хийсэн.<br>2. Уг сургалтанд хамрагдсан ААН-үүдэд 30 зөвлөмж өгсөн. | IV/09 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | Арга хэмжээ 1.5.<br>Цаг үеийн шинжтэй болон онцгой нөхцөл байдалд зохих журмын дагуу ажиллах; | Журмын хэрэгжилт хангагдсан байна. | 2 | Тухай бүрд | Удирдлагаас өгөгдсөн цаг үеийн шинжтэй 11 үүрэг даалгавар, 9 албан бичиг төлөвлөж зохих журмын дагуу ажилласан. | I/02-VI/06 | 100 |
| 6 | Арга хэмжээ 1.6.<br>Байгууллагын болон салбарын сургалтыг зохион байгуулах, үр дүнг тайлагнах; | Сургалт зохион байгуулагдсан байна. | - | | 1.ЗТЯ-ны Их нүүдэл хурлын танхимд "Улсын байцаагчийн нэгдсэн сургалт"-нд 2025.03.11-15-ны өдрүүдэд хамрагдсан.<br>2.Прокурорын байгууллагаас зохион байгуулсан "Зөрчлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан"-г цахимаар ашиглаж, ажиллах тухай сургалтад хамрагдсан. | I/28<br>III/11-15 | 100 |
| 7 | Арга хэмжээ 1.7.<br>Хяналт шалгалтын үр дүнг олон нийтэд мэдээлэх; | Олон нийтийг мэдээллээх хангасан байна. | 3 | Шаардлагатай тохиолдолд шалгалтын үр дүнг мэдээлнэ | Авто замын хяналтын чиглэлээр цаг үеийн мөн авто замын засвар, шинэчлэлийн талаар www.erdenet.mn цахим хуудсанд 3 мэдээлэл, пэйж хуудсанд 29 мэдээллийг хэвлэлийн албатай хамтран хүргэсэн. | I/02-VI/06 | 100 |
| **Зорилт 2. "Улсын байцаагчийн бүрэн эрхийн хүрээнд хяналт шалгалт хийх, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх " зорилтын хүрээнд** | | | | | | | |
| 8 | Арга хэмжээ 2.1.<br>Авто замын салбарын хяналтын чиглэлээр их,дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 12 обьектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах арга хэмжээг авч, улсын байцаагчийн бүрэн эрхийн хүрээнд хяналт шалгалтын баримт бичиг үйлдэх | Хяналт шалгалт хийсэн обьектын тоо, гүйцэтгэлийн хувь.<br><br>Илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, Улсын байцаагчийн шийдвэрийн биелэлт | 13/100%<br><br>91.5 % | 5/100%<br><br>100% | Зам, тээврийн яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2025 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн баталсан 04/06 дугаартай удирдамжийн дагуу их эрсдэлтэй үнэлэгдсэн "Орхон АЗЗА" ТӨХК, "Жавхлан харгуй" ХХК, "Шилдэг зам" ХХК-ны нийт 5 обьектод 04.2.3-Авто замын барилга, их болон ээлжит засвар, шинэчлэлтийн ажлыг шалгах хяналтын хуудас, 04.2.4-Авто замын арчлалт хамгаалалт, урсгал засварын ажлыг шалгах хяналтын хуудсаар төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийсэн. Хяналт шалгалтаар 65 зөрчил илрүүлж, 59 зөрчлийг бүрэн арилгасан байна. Зөрчил арилгалтын хувь 91.3.<br>Шалгалтын явцад 5 албан шаардлага үйлдсэн. Дунд эрсдэлтэй 3, бага эрсдэлтэй 2. Үр дүн: Авто замын чиглэлээр мөрдөгдөж буй хууль сахин мөрдөлтийн дундаж 90,6 үнэлэгдсэн. Эрсдэл үүсэх магадлал 6,3% байна. | | 100 |
| 9 | Арга хэмжээ 2.2.<br>Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлт, | Өргөдөл, гомдлын | 100% | Өргөдөл, гомдлыг хууль, | ЗТЯ-ны улсын ерөнхий байцаагчийн 2025 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн баталсан 04/06 удирдамжийг үндэслэн: | I/15-VI/05 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | өргөдөл, гомдол, мэдээлэл, удирдлагаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийж, шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах арга хэмжээг авч, улсын байцаагчийн бүрэн эрхийн хүрээнд хяналт шалгалтын баримт бичиг үйлдэх, | шийдвэрлэлт / хувь/<br><br>Зөрчил арилгалт /хувь<br>Улсын байцаагчийн шийдвэрийн биелэлт | 100% | журмын дагуу 100%<br><br>Шийдвэрлэж, зөрчлийг 100% арилгуулна. | 1. Орхон аймгийн ЕБС-ын VII сургуулийн албан тоотын хүрээнд “Явган замын ашиглалтын тухай” 04-25-02/056/06 дугаартай улсын ахлах байцаагчийн дүгнэлт,<br>2. ЭБЦТС ТӨХК-ын албан тоотын хүрээнд “Үерийн хамгаалалт, сувгийн ашиглалтын тухай” 04-25-02/056/07 дугаартай улсын ахлах байцаагчийн дүгнэлт,<br>3. Говил багийн засаг даргын албан тоотын хүрээнд “Гүүрэн гарц, ус зайлуулах хоолой, авто замын ашиглалтын тухай” 04-25-02/056/08 дугаартай улсын ахлах байцаагчийн дүгнэлт,<br>4. Баян-өндөр сумын ЗДТГ-ын албан тоотын хүрээнд хүрээнд “Зөрчил арилгуулах тухай” 04-25-02/56/07 дугаартай улсын ахлах байцаагчийн албан шаардлага,<br>5. Хот тохижуулах газрын албан тоотуудын хүрээнд “Орон нутгийн чанартай авто замын ашиглалтын тухай” 04-25-02/56/11 дугаартай, “Дэнж, Эрдэнэ багийн 2,1 км хатуу хучилттай авто замын ашиглалтын тухай” 04-25-02/56/14 дугаартай улсын ахлах байцаагчийн дүгнэлтийг үйлдэж тус тус хүргүүлсэн. Нийт улсын ахлах байцаагчийн 5 дүгнэлт, 1 албан шаардлага үйлдсэн. | | |
| 10 | Арга хэмжээ 2.3.<br>Хүний амь нас, эрүүл мэнд, нийтийн болон орчны аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдэл, хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх. | Шалгалт хийсэн обьектын тоо,<br><br>Илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь,<br>Улсын байцаагчийн шийдвэрийн биелэлт | 51<br><br>96.7%<br><br>100% | 5<br><br>98%<br><br>100% | Зам,тээврийн хөгжлийн яамны салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 04/05 дугаартай удирдамжийн дагуу урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийсэн. Хөрөнгө оруулалтын эх үүсвэр харгалзахгүй Орон нутгийн төсөв болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлуудын хүрээнд гүйцэтгэгч 8 аж ахуй нэгжид урьдчилан сэргийлэх шалгалтыг хийж холбогдох баримт бичгүүдийг хянаж үзээд бэлтгэл ажлыг хангуулах тухай улсын байцаагчийн 96 заалт бүхий 8 албан шаардлагыг хугацаатай хүргүүлсэн. Тайлант хугацаанд хүрэх түвшинг давуулан ажилласан. | I/15-VI/05 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Урьдчилан сэргийлэх шалгалтаар байнга давтан гарч байгаа зөрчлүүд нь Авто зам, замын байгууламжийн барилга, шинэчлэлийн ажлын зураг төсөлд эрх бүхий этгээдээр магадлал хийлгэж, дүгнэлт гаргаж баталгаажуулаагүй, Захиалагч нь Авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэх, саадгүй хэрэгжүүлэхэд шаардагдах зураг төсөл, замын чиг /трасс/, геодезийн цэгүүд, газар эзэмшүүлэх зөвшөөрөл зэргийг гүйцэтгэгчид хүлээлгэн өгч авто замын барилгын ажил явуулах талбайг чөлөөлөх асуудлыг шийдвэрлээгүй, Авто замын барилга, засвар шинэчлэлтийн ажилд мөрдөгдөх байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, менежментийн төлөвлөгөөг баталгаажуулаагүй, хэрэгжилтийг хангуулан ажилладаггүй, тусгай зөвшөөрөлгүйгээр авто зам, замын байгууламжийн зураг төсөл хийдэг, орон нутгийн төсөв болон бусад эх үүсвэрээр хийгдэж буй хөрөнгө оруулалтын ажлуудад техник технологийн хяналт хэрэгжүүлэх арга хэмжээг авдаггүй зэрэг зөрчлүүд байна. | | |
| 11 | Арга хэмжээ 2.4. Өмнөх шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулахаар өгсөн албан шаардлагын биелэлтийг хянах зорилгоор гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх. | Албан шаардлага өгсөн обьектын тоо<br><br>Зөрчил арилгуулалтын хувь | 12/100% | Албан шаардлагаар өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг дүгнэж, тайлагнана. | Гүйцэтгэлийн хяналт шалгалтыг 4 дүгээр улиралд хийнэ. | IV улирал | 100 |
| 12 | Арга хэмжээ 2.6. Шаардлагатай асуудлыг магадлах зорилгоор итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээнд хамруулах, дүгнэлт гаргах | Хууль, журмын дагуу шийдвэрлэгдсэн байна. | 1 | Тухай бүрд | БОЭТ-н дотор талын зам, барилгачны уулзварын замуудын эвдрэл гэмтлийн шалтгааныг тодорхойлох зорилгоор асфальтбетон хольцноос дээж авч лабораторийн шинжилгээнд хүргүүлсэн. | V/15 | 100 |
| 13 | Арга хэмжээ 2.7. Хяналт шалгалтын дүнг нэгтгэн цаашид авах арга хэмжээний санал, | Хуулийн хугацаанд шийдвэрлэгдсэн байна | 2 | 2025.06.10-ны өдрийн дотор ЗТЯамны Салбарын | ЗТЯ-ны салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2025 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 04/03 дугаартай төлөвлөгөөт хяналт шалгалтын удирдамж, | VI/05 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зөвлөмжийг боловсруулах, шалгалтын дүнг холбогдох газарт хүргүүлэх, тодорхой арга хэмжээг авахуулах, хамтран ажиллах | | | хяналтын газарт хүргүүлэх. | 04/05 дугаартай урьдчилан сэргийлэх шалгалтын удирдамж, 04/06 дугаартай төлөвлөгөөт бус шалгалтын удирдамжийн хүрээнд хийгдсэн шалгалтын тоон тайлан, бичмэл тайлан, хавсралт хүснэгтийн хамт 2025.06.05-ны өдрийн ЗДТГ-ын даргын 03/2072 албан тоотоор хугацаанд нь хүргүүлсэн. | | |
| 14 | Арга хэмжээ 2.8. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг зохих хууль, журмын дагуу хэрэгжүүлэх | Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хууль журмын дагуу явуулсан байна | 16 зөрчлийн хэрэг нээж, хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн. | Хууль тогтоомжийн хүрээнд зөрчлийг шалган шийдвэрлэж, хэрэг шийдвэрлэлтийг 100 хувь хангуулсан байна | Зам тээврийн сайдын 2025.05.02-ны өдрийн 01/2025 дугаартай албан тоотыг хүрээнд 69 тээврийн хэрэгсэл бүхий иргэнд төлөвлөгөөт бус шалгалтыг хийсэн. Хяналт шалгалтаар нийт 56 зөрчил илрүүлж газар дээр нь 38 зөрчлийг арилгуулсан. Хүнд даацын тээврийн хэрэгслийн даац хязгаарлалтанд хяналт шалгалтыг хийж Зөрчлийн тухай хуулийн дагуу тайлант хугацаанд нийт 18 тээврийн хэрэгслийг хамруулсан. Замын цагдаагийн тасгийн байцаагчаар зөрчлийн хэрэг нээж, хялбаршуулсан журмаар 18 иргэнд тус нийт 2,700,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан. Даац хэтрүүлсэн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлаж, илүү ачсан 21 тн ачааг буулгуулж, өөр тээврийн хэрэгсэлд ачуулан, даацыг тохируулан хөдөлгөөнд оролцуулсан. | V/02-12 | 100 |
| **Зорилт 3. “ Холбогдох хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх”зорилтын хүрээнд** | | | | | | | |
| 15 | Арга хэмжээ 3.1. Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, дүрэм журам, заавар, стандартыг үйл ажилагаандаа мөрдөж ажиллах | Хууль, журмын хэрэгжилт хангагдсан байна | Хангасан | Архив, албан хэрэг хөтлөлтийн заавар, журмыг мөрдөнө. | 1.2024 оны Авто замын хяналтын улсын байцаагчийн хяналт шалгалтын материалыг “хадгаламжийн нэгж” болгон архивт хүлээлгэн өгсөн.<br>2.Тайлант хугацаанд 11 албан бичиг, 3 өргөдөл хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэсэн.<br>2.Албан тоот-9 төлөвлөж хүргүүлсэн. | I/02-VI/06 | 100 |
| 16 | Арга хэмжээ 3.2. Холбогдох асуудлаар ажлын хэсэг, улсын комисс зэрэгт ажиллах | Хууль, журмын хэрэгжилт хангагдсан байна | 33 | Тухай бүрд нь ажиллана. | Нийт 8 ажилд улсын комиссын бүрэлдэхүүнд ажиллаж, 15 авто зам, замын байгууламжийн барилга угсралт, их засварын ажлыг ашиглалтанд оруулсан | I/02-VI/06 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 17 | Арга хэмжээ 3.3. Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд үнэн зөв авах, хэрэгжилтэд хяналт тавих | Заавар, журам, стандартад нийцсэн байна | 1 | 1 | Авто замын хяналтын улсын байцаагчийн 2024 оны ХАСХОМ-г хугацаанд нь хүргүүлсэн. | I/20 | 100 |
| 18 | Арга хэмжээ 3.4. Удирдлагын хуульд нийцсэн үүрэг даалгаврыг шуурхай биелүүлэх, эргэн мэдээлэх, мэдээллээр хангах | Шаардлагын түвшинд хэрэгжүүлсэн байна | 14 | Тухай бүрд нь шуурхай биелүүлж, эргэн мэдээлэн, мэдээллээр хангана | Иоффис системээр өгөгдсөн удирдлагын нийт 13 үүрэг даалгаврыг хугацаанд хэрэгжүүлж биелэлтийг 100 хангаж ажилласан. Үүнд:<br>1 дүгээр сард-3 үүрэг даалгавар<br>2 дугаар сард -2 үүрэг даалгавар<br>4 дүгээр сард-2 үүрэг даалгавар<br>5 дугаар сард-6 үүрэг даалгавар | I/02-VI/06 | 100 |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/Д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Машин явахад хүндрэлтэй байгаа Дэнжийн авто замд үзлэг хийж, шороо асгаж замыг тэгшлэх | Зөрчил арилсан байна | 1 Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт | Хяналт шалгалт хийгдсэн байна. | Дэнж багийн нутаг дэвсгэрт байрлах асфальт болон хайрган хучилттай авто замд үзлэг шалгалтыг ХЗАлбаны инженер Зоригтбаатартай хамтран хийлээ. Үзлэг шалгалтаар авто замын хатуу болон шороон хучилттай хэсгүүдийн зорчих хэсэг эвдрэл үүсч, гадаргуугийн тэгш байдал хангалтгүй болсон байна. Орхон аймаг нь Монгол орны авто замын уур амьсгалын IIA бүсчлэлд хамаарагддаг. Энэ бүс нутагт өнөөдрийн байдлаар хөрсний хөлдөлт 2,5-3,5 метрийн гүнд үүссэн, нөөц ордоос хайрга шороо авах нөхцөлгүй тул Авто замын угсралт, засварын ажлыг 10 дугаар сарын 20-ны өдрөөс 4 дүгээр сарын 20-ны өдрүүдэд хийх боломжгүй юм. Зөвхөн хүйтэн асфальтбетоныг 3 дугаар сарын 05-наас 11 сарын 22-ны өдрийн дотор хийх боломжтой. Үүрэг даалгаврын дагуу хариуцагч байгууллага болох ХТГазарт чиглэл өгч болзошгүй аваарын зардлаар гүйцэтгэсэн шороон хучилттай хэсэгт грейдэрийг газар дээр нь ажиллуулсан боловч ажил гүйцэтгэх ямарч боломжгүй хөлдсөн байна. ХТГазар нь дотоод нөөц бололцоогоо ашиглан асфальтбетон хучилтанд үүссэн нүхэн эвдрэлүүдэд шороо хийж | I/13-17 | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | дүүргэсэн. Цаашид болзошгүй аваарын зардлаар хийж гүйцэтгэж байгаа авто замын засварын ажлуудыг авто замын тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэж, гэрээний хэрэгжилтийг хангуулж, явцын хяналтыг эрчимжүүлж, чанарын баталгаат хугацаанд нь гүйцэтгэгчид бүрэн хариуцуулах шаардлагатай талаар ХЗАлбанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн. | | |
| 2. | Орхон аймагт явган замын хавтан үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүний чанарт албан ёсны дүгнэлтийг гаргаж, үйлдвэрлэгч болон хэрэглэгчдэд мэдээлэх | Авто замын тухай хуулийн хэрэгжилт хангагдана. | 3 обьект | Үйлдвэрлэл эрхэлж буй нэгжүүдийг бүрэн хамруулна. | Орхон аймгийн хэмжээнд явган замын бүтээгдэхүүн үйлдэрлэж буй “Одон трейд” ХХК, “Мөнгөн Саахуу” ХХК, “Зөвт цамхаг” ХХК-иудын үйл ажиллагаанд 2023 онд хяналт шалгалтыг хийж “ТУХАЙН ҮЙЛДВЭРЛЭЛ НЬ СТАНДАРТЫН ШААРДЛАГА” хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжгүй нь тогтоогдсон тул үйл ажиллагааг зогсоож, улсын байцаагчийн албан шаардлагыг хүргүүлж, биелэлтийг 100 хангаагүй, хангах боломжгүй байсан. Үүрэг даалгаврын хүрээнд дээрх 3 обеьктод төлөвлөгөөт бус шалгалтыг хийж мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласан. | V/12-16 | 100 |
| 3. | Хуучин авто замын постыг буулгах ажлыг зохион байгуулах | Зөрчил арилсан байна. | - | ТАЦэг буусан байна. | Төлбөр авах цэгийн барилгыг 2025 оны 06 дугаар сарын 01-ны өдрийн дотор бүрэн хэмжээнд буулгаж, авто замын засварын ажлыг хийлгүүлэх, зөрчил арилгуулах тухай 2025.05.23-ны өдрийн улсын ахлах байцаагчийн 04-25-02/56/08 дугаартай хугацаатай албан шаардлагыг “Хүчит зам” ХХК”-д хүргүүлсэн. | V/19-23 | 100 |
| 4. | Нутгийн удирдлагын ордны арын авто зогсоолд тусгаарласан цагаан зураас хийх, баруун хойшоо гарах шат хийх ажлыг яаравчлах | Үүрэг даалгавар биелсэн байна. | - | Цагаас зураас, шат хийгдсэн байна, | Тус ажлыг хийх зураг, төсвийг хийж, хөрөнгийг шийдвэрлүүлэхээр ХБТХОХэлтэст хүргүүлсэн. Хугацаатай үүрэг даалгаврын хүрээнд “Жи Пи Экспресс финанс” ХХК”-тай харилцан ярилцаж 2025.05.23-ны өдрөөс явган замын ажил эхэлж төлөвлөсөн хугацаанд дууссан. Авто зогсоолын хэвтээ тэмдэглэгээг 2025.06.03-ны өдөр хийж дуусгасан. | V/19-23 | 100 |
| 5. | Авто зам, зам засварын ажлын мэдээллийг тодорхой болгож иргэдэд мэдээлэх. Үүнд аль аль замыг ямар ХХК гүйцэтгэж байгаа, | Зөрчил арилсан байна. | - | Самбар байршсан байна. | Авто замын ажлын мэдээллийг төсөл бүр дээр иргэдэд мэдээлэх зорилгоор ажлын талбай дээр самбарыг байршуулах үүрэг даалгаварыг гүйцэтгэгч ХХК-иудад өгсөн. Гүйцэтгэгч компаниуд нь ХББЗАлбанаас гаргасан загварын дагуу мэдээлэх самбарыг өнөөдрийн байдлаар 8 ажил | V/26-30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | гүйцэтгэх явцад мэдээллийн самбар байрлуулах | | | | дээр байршуулсан байна. Одоо байгаа мэдээлэх самбарын мэдээлэл нь шаардлага хангахгүй байгаа тул тус самбар дээр байх ёстой мэдээллийг шинэчилж, гүйцэтгэгч компаниудад хүргүүлээд байна. 2025.06.05-ны өдрийн дотор ажлын талбар дээр бүрэн байршуулулна. | | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/Д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дуусан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. “Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх” зорилтын хүрээнд** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.<br>Монгол хэл бичгийн цахим бичвэрийн сургалтад хамрагдах. | Монгол бичгийн ахисан шатны түвшингийн мэдлэгтэй болох | 2 | Сургалтад хамрагдсан байх. | Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу монгол бичгийн цахим бичвэрийн 14 удаагийн 28 цагийн сургалтад хамрагдсан. | II/03-V/07 | 100 |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**
**АВТО ЗАМЫН ХЯНАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ** [signature] **Ш.СҮНЖИДМАА**